



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
Т У Ш А А Л

2019 оны 03 дугаар
сарын 01 - ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тос боловсруулах аж үйлдвэрийн цогцолбор байгуулах төслийн үйл ажиллагаанд хяналт тавьж, уялдуулан зохицуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн дарга

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Г.Баясгалан

Гишүүд:

- Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батбилэг;

- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн;

- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт;

- Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн;

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал;

- “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг.

Нарийн бичгийн дарга

- Засгийн газрын референт Д. Болд

2. Газрын тос боловсруулах аж үйлдвэрийн цогцолборыг байгуулах явцад тулгамдаж байгаа асуудлыг цаг тухайд нь шуурхай шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Ажлын хэсэг /Г.Баясгаланд/-т даалгасугай.

Монгол улсын сайд
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ